**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 30 өдөр Дугаар А/403 Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 19,051,915.35 (арван есөн сая тавин нэгэн мянга есөн зуун арван таван төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургууль (Д.Ариунаа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 11217 ширхэг нийт 19,051,915.35 (арван есөн сая тавин нэгэн мянга есөн зуун арван таван төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургууль (Д.Ариунаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ<br>ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1150591201

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны X . . дугаар сарын 10 . -ны өдрийн А/418 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 60 дугаар сургууль

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын санал | ҮХХХК-ын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ном, сурах бичиг | 10-8. | ш | 11217 | - | 19,051,915.35 | - | - | Хичээлийн хөтөлбөр өөрчлөгдсөн.Эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон. | Дансаас хасах | Дансаас хасах | Данс бүртгэлээс хасах |
| Нийт дүн | | | | | | 19,051,915.35 | 0.00 | 0.00 | | | | |